



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 4/38

Хажуу шинэ ус

2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг
татлага явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.4, “Цэргийн албаны тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалт Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны А/141 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн 09:00 цагт Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулсугай.

2. Цэрэг татлага зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Өлзийтогтох (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд Д.Сарангэрэл (Засаг даргын орлогч)
Э.Ванчиндорж (Хэсгийн төлөөлөгч)
Б.Мөнхтөгөлдөр (1 дүгээр багийн Засаг дарга)
Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга)
Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)
Д.Бадамбаяр (Лаборант)
Н.Долгорсүрэн (Их эмч)
П.Цэцэгмаа (Бага эмч)

3. Цэрэг татлагын товчоогоор орох цэргийн насны залуучуудад зарлан дуудах мэдэгдлийг албан ёсоор хүргүүлж иргэдээ бүрэн хамруулж 5-аас дээшгүй залуучуудыг үзлэгт нэг дор оруулан зохион байгуулахыг хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цэрэг татлагын байрыг журмын дагуу бэлтгэхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Өлзийтогтох)-д даалгасугай.

5. Тус үйл ажиллагааны зардал 280.000 (хоёр зуун наян мянган) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын нягтлан бодогч (Э.Уранбилэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН